



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар A/155

Чингис хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдтай байгуулсан 2018 онд хамтран ажиллах гэрээний 2.12, 3.10-т заасны дагуу “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийг зохион байгуулахтай холбогдуулан Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэдийг 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 08.00 цагаас 04 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүтсүгэй.

2. Гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, алба мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг үүрэгт ажилд нь оруулах, хүн хүч, техник хэрэгслийг тодотгож бэлэн байдлыг хангуулах, штабын үйл ажиллагааг 24 цагийн горимд шилжүүлж, жижүүрийг томилох, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг сум, багийн Засаг дарга болон төсвийн шууд захирагч, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Сургуулийн төв удирдлага, штабын байрыг байгуулах, шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ширээ сандлаар хангаж, оюутан сурагчдын хичээлд зохицуулалт хийж ажиллахыг Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Г.Нямхатанд даалгасугай.

4. Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд шуурхай хүргэж ажиллахыг Сурталчилгааны албаны дарга Б.Мөнхбаатар, Мэдээлэл харилцаа холбооны албаны дарга О.Од-Эрдэнэ нарт даалгасугай.

2//.

5. Зайлшгүй шалтгаанаар сургуулийн үйл ажиллагаанаас чөлөөлөгдөх шаардлага гарвал зөвхөн сургуулийн удирдагчийн зөвшөөрлөөр шийдвэрлэх, хүндэтгэх шалтгаангүй нэгдсэн шуурхай цугларалт, сургалт, дадлагаас хоцорсон, тасалсан томилгоот бүрэлдэхүүнд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа Д.Батжаргалд даалгасугай.

6. Олон нийтийг хамарсан тэмцээн, уралдаан, соёл урлагийн арга хэмжээ, бусад сургалт семинар зохион байгуулах, архи согтууруулах ундааны худалдаа үйлчилгээг зогсоохыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч Ц.Идэрбатад даалгасугай.

7. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан үүргийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга хурандаа Д.Батжаргал, Цагдаагийн газрын дарга дэд хурандаа Ж.Болд, Мэргэжлийн хяналтын албаны дарга Б.Сүнгээ нарт тус тус үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

